



БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Булган аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: БУА-2023/149/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.bulgan@audit.gov.mn Булган аймаг Булган сум 2023 он	Булган аймаг дахь ТАГ-н дарга, Тэргүүлэх аудитор: Б.Эрдэнэ Утас: 89009802 Цахим хаяг: erdeneb@audit.gov.mn Аудитын менежер: Ж.Энхцоодол Утас: 99057478 Цахим хаяг: enhtsoodolj@audit.gov.mn Ахлах аудитор: Утас: Цахим хаяг: Аудитор: Б.Золжаргал Утас: 90119931 Цахим хаяг: zoljargalb@audit.gov.mn
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт.....
 2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл
 3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....
 - 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа
 - 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин
 - 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....
 - 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт.....
 4. Аудитын тайлан
 - 4.1 Ерөнхий зүйл
 - 4.2 Материаллаг байдал
 - 4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....
 - 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал
 - 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
 - 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал
5. Аудитын илрүүлэлт
 6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл.....

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ГЗБГЗЗГ	Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газар
БХБЯ	Барилга, хот байгуулалтын яам

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



БУЛГАН АЙМГИЙН ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,
Жаргалант баг, Булган сум, Булган аймаг, 63082
Утас/Факс: 7034-2580
E-mail: bulgan@audit.gov.mn

2023.08.24 № 113
танай _____ ны № _____ т

ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА
ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН
ДАРГА Ү.БЯМБАСҮРЭН ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүссэн тухай санхүүгийн тайландаа тодруулаагүй байна.

Аудитын гол асуудал

Үндсэн үйл ажиллагааны хүрээнд техник хяналтын ажил гүйцэтгэж нийт 247,4 сая төгрөгийн орлого бий болгосноос 64.7 хувь буюу 160,07 сая төгрөг нь Эрдэнэт үйлдвэр ТӨХК-тай хийсэн техник хяналтын ажил гүйцэтгэх гэрээний орлого байна. 2022 онд үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих орлогын төлөвлөгөө 70,0 сая төгрөгөөр батлагдаж 79.03 сая төгрөгийг Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газрын төвлөрүүлэх орлогын дансанд, 108,7 сая төгрөгийг орон нутгийн дансанд тус тус төвлөрүүлсэн байна.

D:\bichighereg\2022\41\oot

006020120

Бусад асуудлын хэсэг

Булган хотын Газар зохион байгуулалтын Ерөнхий төлөвлөгөөг Азийн хөгжлийн банкны хөрөнгө оруулалтаар хийж 2022 оны 2-р улиралд аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлаар батлуулсан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.ЭРДЭНЭ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	59,105,141.56	60,924,203.56
35	БАРАА МАТЕРИАЛ	59,105,141.56	60,924,203.56
351	Түүхий эд материал	10,772,180.00	7,371,200.00
35110	Тусгай зориулалттай материал	10,772,180.00	7,371,200.00
354	Хангамжийн материал	48,332,961.56	53,553,003.56
35410	Бичиг хэргийн материал	15,643,666.61	16,115,281.61
35420	Аж ахуйн материал	28,624,423.95	32,907,423.95
35430	Сэлбэг хэрэгсэл	372,000.00	372,000.00
35470	Бусад хангамжийн материал	798,150.00	593,300.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	590,400,337.12	518,155,683.19
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	590,400,337.12	518,155,683.19
392	Биет хөрөнгө	569,810,337.04	497,945,683.03
39201	Барилга, байгууламж, орон сууц	409,423,075.72	409,423,075.72
39202	Хуримтлагдсан элэгдэл	-36,259,815.30	-50,763,741.42
39203	Авто-тээврийн хэрэгсэл	41,000,000.00	41,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-10,650,000.12	-19,700,000.16
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	278,166,051.79	292,699,196.79
39206	Хуримтлагдсан элэгдэл	-126,500,466.07	-185,264,710.53
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	35,353,052.71	35,353,052.71
39208	Хуримтлагдсан элэгдэл	-20,721,561.69	-24,801,190.08
393	Биет бус хөрөнгө	20,590,000.08	20,210,000.16
39301	Програм хангамж	2,380,000.00	2,380,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-1,259,999.92	-1,639,999.84
39303	Бусад биет бус хөрөнгө	19,470,000.00	19,470,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	649,505,478.68	579,079,886.75
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	649,505,478.68	579,079,886.75
51	Засгийн газрын хувь оролцоо	649,505,478.68	579,079,886.75
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	427,169,483.31	427,169,483.31
51101	Өмч: - төрийн	427,169,483.31	427,169,483.31
512	Хуримтлагдсан үр дүн	127,947,566.85	57,521,974.92
51210	Өмнөх үеийн үр дүн	127,947,566.85	127,947,566.85
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-70,425,591.93
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	94,388,428.52	94,388,428.52
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	649,505,478.68	579,079,886.75

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	779,100,216.40	761,389,777.34
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	198,357,305.00	3,524,092.00
120	Нийтлэг татварын бус орлого	198,357,305.00	3,524,092.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	198,357,305.00	3,524,092.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	20,712,277.00	2,822,340.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	177,645,028.00	701,752.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	86,878,211.40	757,865,685.34
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	00.00	505,554,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	00.00	505,554,200.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	493,864,700.00	00.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	54,559,659.40	247,423,540.34
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	53,659,659.40	247,423,540.34
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	900,000.00	00.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	28,008,052.00	00.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	28,008,052.00	00.00
1330	Төсвийн захирагчдаас	4,310,500.00	4,887,945.00
133003	Хөрөнгийн	4,310,500.00	4,887,945.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	676,488,932.78	827,937,029.27
21	УРСГАЛ ЗАРДАЛ	676,488,932.78	827,937,029.27
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	583,529,584.26	600,976,494.25
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	373,247,377.60	371,050,001.00
210101	Үндсэн цалин	280,768,247.60	284,133,828.00
210102	Нэмэгдэл	76,290,321.00	55,965,054.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	9,954,000.00	10,605,000.00
210104	Урамшуулал	00.00	20,346,119.00
210105	Гэрээт ажлын хөлс	6,234,809.00	00.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	45,652,616.28	47,861,497.32
210201	Тэтгэврийн даатгал	34,582,333.48	33,136,720.52
210202	Тэтгэмжийн даатгал	2,914,686.67	3,838,965.40
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,313,548.89	2,983,812.59
210204	Ажилгүйдлийн даатгал	572,438.08	718,363.25
210205	Эрүүл мэндийн даатгал	5,269,609.16	7,183,635.56
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	27,508,052.00	26,732,459.00
210301	Гэрэл, цахилгаан	1,633,452.00	1,676,391.00
210302	Түлш, халаалт	25,238,400.00	24,288,268.00
210303	Цэвэр, бохир ус	636,200.00	767,800.00
2104	Хангамж, бараа материалын зардал	16,560,624.00	14,441,740.70
210401	Бичиг хэрэг	9,234,380.00	5,961,615.00
210402	Тээвэр, шатахуун	6,632,294.00	7,005,514.70
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	436,200.00	442,911.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	257,750.00	1,031,700.00
2105	Нормативт зардал	343,200.00	275,600.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	00.00	40,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	343,200.00	235,600.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	500,000.00	1,329,500.00
210604	Урсгал засвар	500,000.00	1,329,500.00
2107	Томилолт, зочны зардал	2,502,500.00	5,530,700.00
210702	Дотоод албан томилолт	2,502,500.00	5,530,700.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	242,500.00	22,000.00

210803	Даатгалын үйлчилгээ	94,000.00	22,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	148,500.00	00.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	116,972,714.38	133,732,996.23
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	27,831,049.00	46,480,297.30
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,125,000.00	474,900.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	88,016,665.38	86,777,798.93
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	92,959,348.52	226,960,535.02
2132	Бусад урсгал шилжүүлэг	14,223,300.00	14,870,300.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	00.00	2,270,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	12,318,300.00	12,600,300.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,905,000.00	00.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	15,884,883.12	11,467,136.68
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	15,884,883.12	11,467,136.68
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	00.00	108,780,324.34
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	108,780,324.34
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	62,851,165.40	91,842,774.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	62,851,165.40	91,842,774.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>102,611,283.62</u>	<u>-66,547,251.93</u>
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	00.00	3,878,340.00
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	00.00	3,878,340.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	00.00	-3,878,340.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>102,611,283.62</u>	<u>-70,425,591.93</u>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	597,144,688.40	755,800,080.34
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	20,712,277.00	2,822,340.00
120	Нийтлэг татварын бус орлого	20,712,277.00	2,822,340.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	20,712,277.00	2,822,340.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	20,712,277.00	2,822,340.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	576,432,411.40	752,977,740.34
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	00.00	505,554,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	00.00	505,554,200.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	493,864,700.00	00.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	54,559,659.40	247,423,540.34
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	53,659,659.40	247,423,540.34
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	900,000.00	00.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	28,008,052.00	00.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	28,008,052.00	00.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	589,640,388.40	745,942,280.34
21	УРСГАЛ ЗАРДАЛ	589,640,388.40	745,942,280.34
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	496,681,039.88	518,981,745.32
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	373,247,377.60	371,050,001.00
210101	Үндсэн цалин	280,768,247.60	284,133,828.00
210102	Нэмэгдэл	76,290,321.00	55,965,054.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	9,954,000.00	10,605,000.00
210104	Урамшуулал	00.00	20,346,119.00
210105	Гэрээт ажлын хөлс	6,234,809.00	00.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	45,652,616.28	47,861,497.32
210201	Тэтгэврийн даатгал	34,582,333.48	33,136,720.52
210202	Тэтгэмжийн даатгал	2,914,686.67	3,838,965.40
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,313,548.89	2,983,812.59
210204	Ажилгүйдлийн даатгал	572,438.08	718,363.25
210205	Эрүүл мэндийн даатгал	5,269,609.16	7,183,635.56
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	27,508,052.00	26,732,459.00
210301	Гэрэл, цахилгаан	1,633,452.00	1,676,391.00
210302	Түлш, халаалт	25,238,400.00	24,288,268.00
210303	Цэвэр, бохир ус	636,200.00	767,800.00
2104	Хангамж, бараа материалын зардал	14,334,600.00	13,147,296.00
210401	Бичиг хэрэг	4,415,400.00	4,753,030.00
210402	Тээвэр, шатахуун	8,857,400.00	6,919,655.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	436,200.00	442,911.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	625,600.00	1,031,700.00
2105	Нормативт зардал	343,200.00	275,200.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	343,200.00	275,200.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	500,000.00	1,329,500.00
210604	Урсгал засвар	500,000.00	1,329,500.00
2107	Томилолт, зочны зардал	2,502,500.00	5,530,700.00
210702	Дотоод албан томилолт	2,502,500.00	5,530,700.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	242,500.00	22,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	94,000.00	22,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	148,500.00	00.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	32,350,194.00	53,033,092.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	31,225,194.00	52,558,192.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,125,000.00	474,900.00

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	92,959,348.52	226,960,535.02
2132	Бусад урсгал шилжүүлэг	14,223,300.00	14,870,300.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	00.00	2,270,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	12,318,300.00	12,600,300.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,905,000.00	00.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	15,884,883.12	11,467,136.68
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	15,884,883.12	11,467,136.68
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	00.00	108,780,324.34
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	108,780,324.34
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	62,851,165.40	91,842,774.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	62,851,165.40	91,842,774.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	7,504,300.00	9,857,800.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	7,504,300.00	9,857,800.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	7,504,300.00	9,857,800.00
2200	Дотоод эх үүсвэрээр	7,504,300.00	9,857,800.00
222001	Тоног төхөөрөмж	00.00	9,857,800.00
223001	Бусад хөрөнгө	7,504,300.00	00.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-7,504,300.00	-9,857,800.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	20.. оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	00.00	00.00	00.00	00.00	00.00
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	00.00	00.00	00.00	00.00	00.00
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	00.00	00.00	00.00
C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	427,169,483.31	94,388,428.52	127,947,566.85	00.00	649,505,478.68
D01	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	427,169,483.31	94,388,428.52	127,947,566.85	00.00	649,505,478.68
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	427,169,483.31	94,388,428.52	127,947,566.85	00.00	649,505,478.68
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-70,425,591.93	00.00	-70,425,591.93
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	427,169,483.31	94,388,428.52	57,521,974.92	00.00	579,079,886.75

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	505,554,200.00	496,909,403.32
21	УРСГАЛ ЗАРДАЛ	505,554,200.00	496,909,403.32
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	490,683,400.00	479,231,763.32
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	381,142,700.00	371,050,001.00
210101	Үндсэн цалин	298,947,400.00	284,133,828.00
210102	Нэмэгдэл	72,036,400.00	55,965,054.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	10,158,900.00	10,605,000.00
210104	Урамшуулал	00.00	20,346,119.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	48,845,800.00	47,861,497.32
210201	Тэтгэврийн даатгал	33,309,800.00	33,136,720.52
210202	Тэтгэмжийн даатгал	3,884,000.00	3,838,965.40
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,107,200.00	2,983,812.59
210204	Ажилгүйдлийн даатгал	776,800.00	718,363.25
210205	Эрүүл мэндийн даатгал	7,768,000.00	7,183,635.56
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	26,930,700.00	26,732,459.00
210301	Гэрэл, цахилгаан	2,655,100.00	1,676,391.00
210302	Түлш, халаалт	20,610,600.00	24,288,268.00
210303	Цэвэр, бохир ус	3,665,000.00	767,800.00
2104	Хангамж, бараа материалын зардал	13,169,300.00	13,168,966.00
210401	Бичиг хэрэг	4,790,400.00	4,774,700.00
210402	Тээвэр, шатахуун	7,102,600.00	6,919,655.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	349,700.00	442,911.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	926,600.00	1,031,700.00
2105	Нормативт зардал	275,200.00	275,200.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	275,200.00	275,200.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,329,500.00	1,329,500.00
210604	Урсгал засвар	1,329,500.00	1,329,500.00
2107	Томилолт, зочны зардал	5,551,200.00	5,530,700.00
210702	Дотоод албан томилолт	5,551,200.00	5,530,700.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	176,700.00	22,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	68,500.00	22,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	108,200.00	00.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	13262300.00	13261440.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	12,787,400.00	12,786,540.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	474,900.00	474,900.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	14870800.00	14870300.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	14,870,800.00	14,870,300.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	2,270,500.00	2,270,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	12,600,300.00	12,600,300.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	505,554,200.00	508,376,540.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	505,554,200.00	505,554,200.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	505,554,200.00	505,554,200.00
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	00.00	2,822,340.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	2,822,340.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	34.00	31.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		128,785,416.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ		128,785,416.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		39,749,982.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		39749982.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		39,749,982.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг		89,035,434.00
213503	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг		89,035,434.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		9,857,800.00
2200	Дотоод эх үүсвэрээр		9,857,800.00
222001	Тоног төхөөрөмж		9,857,800.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		247423540.34
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		247,423,540.34
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		247,423,540.34
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Газрын харилцаа, барилгын салбарын багц хуулиудыг хэрэгжүүлэх ажлыг орон нутагт үр дүнтэй зохион байгуулж, газрын шинэтгэлийн бодлогыг эрчимжүүлж, газрыг эдийн засгийн эргэлтэд оруулах, барилга хот төлөвлөлтийн үйл ажиллагааг орчин үеийн мэдээллийн технологид түшиглэн иргэдийн амьжиргааны түвшнийг сайжруулахад чиглэсэн үйлчилгээг нээлттэй, шуурхай үзүүлэхэд чиглэгдсэн.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант онд тухайн байгууллагад мөрддөг БХБС-дын 2022 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн 83-р тушаал, Хөдөлмөрийн тухай хууль, Сангийн сайдын 2022 оны 190 дугаар тушаалаар батлагдсан албан томилолтын зардлын тарифт өөрчлөлт оруулах тухай, Төрийн хэмнэлтийн тухай хууль, төрийн зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох Засгийн газрын 2022 оны 03 дугаар сарын 09-ний өдрийн 107 дугаар тогтоол, 05 дугаар сарын 11-ний өдрийн 192 дугаар тогтоолд тус тус өөрчлөлт орсон байна.

Тухайн байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Хувь хүний орлогын албан татварын тухай хууль, Шилэн дансны хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Газрын тухай хууль, Газрын төлбөрийн тухай хууль, Газар өмчлүүлэх тухай хууль, Кадастрын зураглал газрын кадастрын тухай хууль, Төрийн болон албаны нууцын тухай, Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай, Хаягжуулалтын тухай хууль, Барилгын тухай хууль, Засаг захиргаа нутаг дэвсгэр түүний удирдлагын тухай хууль болон бусад хууль, тогтоомжууд, эрх зүйн актуудыг мөрдлөг болгон ашигласан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузель сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын даргын баталсан “нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг мөрдөн ажилладаг. Үйл ажиллагаанд нийцэж байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 69.3 сая төгрөгөөр буюу 10.67 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0.00	0.00	0.00
Авлага	0.00	0.00	0.00
Бараа материал	59,105.14	60,924.20	1,819.06
Үндсэн хөрөнгө	590,400.33	519,203.35	-71,196.98
Нийт хөрөнгө	649,505.47	580,127.55	-69,377.92
Өр төлбөр	0.00	0.00	0.00
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	427,169.48	427,169.48	0.00
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	649,505.47	580,127.55	-69,377.92

Бараа материалын дансны үлдэгдэл 60,924.20 мянган төгрөг болж 1,819.06 мянган төгрөгөөр өссөн нь тайлант хугацаанд худалдаж авсан бараа материалын өсөлтөөс үүссэн байна.

Үндсэн хөрөнгийн үлдэгдэл 519,2 сая төгрөг болж өмнөх оноос 71,1 сая төгрөгийн элэгдлийн зардлаар буурсан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 505,5 сая, нийт зарлагыг 553.85 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас цалин, хөлс нэмэгдэл урамшил зардлыг 10.7 сая, нийгмийн даатгалын зардлыг 2.8 сая төгрөгөөр нэмж, хангамж, бараа материалын зардлыг 16.7 сая, томилолт зочны зардлыг 1.7 сая, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 170.7 сая, бараа үйлчилгээний бусад зардлыг 8.1 сая төгрөгөөр бууруулж баталсан байна. Энэ нь 2022 оны төсвийн төслийг бодитой, үндэслэлтэй боловсруулаагүй хэт өндөр тооцоноос шалтгаалсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх газрын зураглал, кадастр /71504/ хөтөлбөрийн үндсэн үйл ажиллагааны арга хэмжээг санхүүжүүлэхээр 505.5 сая төгрөгийг улсын төсвөөс бүрдүүлэхээр байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 505.5 сая төгрөгийн санхүүжилт олгож, зарцуулагдаагүй үлдэгдэл 11.45 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 494,1 сая төгрөг буюу 97.73 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 11.45 сая төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

				/мянган төгрөгөөр/	
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	71504-Газрын зураглал, кадастр	505,554.2	494,102.07	11,452.13	97.73%
1.1	Үндсэн үйл ажиллагааны зардал	477,896.00	465,970.32	11,450.77	97.50%
1.2	Ажил олгогчоос олгох тэтгэмж, шагнал урамшуулал	14,870.80	14,870.30	0.50	99.99%
1.3	Барилгын техник хяналт	12,787.40	12,786.54	0.86	99.99%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Үндсэн үйл ажиллагааны зардлын зарцуулагдаагүй үлдэгдэл болох 11.45 сая төгрөгийн үлдэгдэл нь хэмнэсэн орон тооноос үүссэн цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал 11.07 сая, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 0.19 сая, дотоод албан томилолтын зардал 0.02 сая, бусдаар гүйцэтгүүлсэн бараа, ажил үйлчилгээний зардал 0.15 сая төгрөг байна.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

/мянган төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	71509-БХБНАА-н бодлого удирдлага	56,820.57	49,907.77	6,912.80	87.8%
1.1	Гэрээт ажилчдын зардал	13,753.23	11,827.03	1,926.20	85.9%
1.2	Барилгын техник хяналтын зардал	43,067.34	38,080.74	4,986.60	88.4%

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

Нэмэлт санхүүжилтийн дансанд техник хяналтын орлого болох 247,4 сая төгрөгийн санхүүжилт 187.73 сая төгрөгийн татан төвлөрүүлсэн байна.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант хугацаанд төсөл хөтөлбөр хэрэгжүүлэхээр төлөвлөөгүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах үндсэн хөрөнгөтэй холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Булган аймаг дахь ТАГ-н аудитор Б.Золжаргал гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Ж.Энхцоодол, газрын дарга, Тэргүүлэх аудитор Б.Эрдэнэ нар тус тус хэрэгжүүлсэн.

Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Булган аймаг дахь ТАГ-т 2023 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 01/72 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлаас сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны нийт зардлаас буюу 745.9 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 8.39 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага чиг үүрэг, орон тоог давхардуулан тогтоолгүй ажиллаж 11.45 сая төгрөгийн хэмнэлтийг бий болгожээ.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нэмэлт санхүүжилтийн дансны орлого болох үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон техник хяналтын орлогыг зарцуулахдаа зардлын эдийн засгийн ангилал тус бүрээр эрх нээлгэлгүй ганцхан бараа үйлчилгээний бусад зардлын дансаар эрх нээлгэж зарцуулалт хийсэн нь Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалын хавсралт “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” заалтыг мөрдөж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь:

“Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”-ыг мөрдөж ажиллах албан шаардлага хүргүүлэв.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Тайлант онд завсрын аудит хийгдээгүй байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Хүснэгт: 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	1	767.69	1	767.69	100%
Зөвлөмж					
Нийт дүн	1	767.69	1	767.69	

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар батлагдсан “зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”-ын дагуу үйл ажиллагааны зардлыг хуримтлуулан бүртгэсэн эсэх асуудлыг дараагийн аудитаар авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 16.6 сая төгрөгийн алдаа¹ илэрснээс дансны давхар бичилт хийгээгүй шууд зардалд бичсэн 16.6 сая төгрөгийн 29 ажил гүйлгээг аудитын явцад залруулав.

5.1 Төлбөрийн акт

Төлбөрийн акт бичигдээгүй.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

5.2 Албан шаардлага

Нэмэлт санхүүжилтийн дансны орлого болох үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон техник хяналтын орлогыг зарцуулахдаа зардлын эдийн засгийн ангилал тус бүрээр эрх нээлгэлгүй ганцхан бараа үйлчилгээний бусад зардлын дансаар эрх нээлгэж зарцуулалт хийсэн нь Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалын хавсралт “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" заалтыг мөрдөж ажиллаагүй тул албан шаардлага хүргүүлэв.

5.3 Зөвлөмж

Санхүүгийн тайлан баталгаажуулах аудитаар зөвлөмж хүргүүлээгүй.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

